Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
2024 оны ...12... дугаар сарын ...10... ний өдрийн
...08/255... дугаар албан бичгийн нэгдүгээр хавсралт

9024010070 СТС4589 9077448

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2021-2024 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023-2024 ОНЫ БИЕЛЭЛТ

2024 оны 12 дугаар сарын 05 Улаанбаатар хот

| № | Бодлогын баримт бичигт тусгагдсан болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт | Стратеги арга зам | Зарцуулсан төсөв (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2019 он) | Зорилтот түвшин (2020-2024 он) | Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар) |
|---|---|---|---|---|---|---|---|
| Ерөнхий чиг үүргийн нэр: Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангах. | | | | | | | |
| Үндсэн чиг үүргийн нэр: Иргэдийн идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлж, эрүүл мэндээ хамгаалах, хичээллэх орчин, нөхцөлийг бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй болгох. | | | | | | | |
| 1. | Зорилт 1. Иргэдэд хүргэх биеийн тамир, спортын арга хэмжээ, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Арга хэмжээ 1. Нийслэлийн иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн биеийн тамирын үйл ажиллагааг өргөжүүлж, нийтийг хамарсан арга хэмжээнүүдийг зохион байгуулна. | Улсын төсвөөс 701.5<br><br>Нийслэлийн төсвөөс 1,018.2<br>Орон нутгийн төсөв 565,7 | Биеийн тамирын үйл ажиллагаанд оролцогчдын тоо (өссөн дүнгээр) | 756,451 | 2021 онд 789451<br>2022 онд 822451<br>2023 онд 855451<br>2024 онд 888451 | Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтаас шалтгаалан Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2021 онд биеийн тамирын 6 арга хэмжээ, 13 удаагийн цахим сургалтыг зохион байгуулж 89,449 иргэнд хүргэж ажилласан бол нийслэл дүүргийн хэмжээнд 340 арга хэмжээг цахим болон практик хэлбэрээр зохион байгуулж 2876 байгууллагын 635.486 иргэнийг хамруулсан.<br>2022 онд нийслэл, дүүргийн хэмжээнд биеийн тамирын 340 арга хэмжээнд 1,170,073 иргэн хамруулсан. Үүнээс:<br>Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 14 арга хэмжээг зохион байгуулж 9407 байгууллагын 423,511 иргэнийг хамруулсан.<br>2023 онд нийслэл, дүүргийн хэмжээнд 368 арга хэмжээнд 9930 байгууллагын 873,313 иргэдийг хамруулсан. Үүнээс: Нийслэлийн Биеийн тамир, |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | спортын газраас нийтийг хамарсан 24 арга хэмжээ зохион байгуулж 2481 байгууллагын 416,000 иргэнийг хамруулсан.<br>Нийслэл, дүүргүүдийн хэмжээнд 2024 онд 345 арга хэмжээ зохион байгуулж 6413 байгууллагын 888500 иргэдийг хамруулсан. Үүнээс: Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2024 онд 17 үйл ажиллагаа зохион байгуулж (сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн багш нарын сургалт, аэробикийн сургалт, хөгжөөн дэмжигчдийн арга хэмжээ, цэцэрлэгийн уран хөдөлгөөнт гимнастик, софт, хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил, шүүгчдийн сургалт, “Улаанбаатар марафон-2024”, “Алхацгаая гүйцгээе” хөдөлгөөн, олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн арга хэмжээ, “Даншиг наадам-хүрээ цам” наадам, Нүүдэлчин, Спорт явган аяллын шигшээ тэмцээн, Автомашингүй өдөр арга хэмжээ, Нийслэлийн Иргэдийн спортын XII наадам, ЕБС-ийн сурагчдын уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээн) 1995 байгууллага, 450.200 иргэнийг хамруулсан.<br>Үр дүн: Нийслэлийн иргэдийн дунд нийтийг хамарсан арга хэмжээ, ажил үйлчилгээнд 2019 онд 756,451 иргэдийг хамруулж байсан бол 2024 онд нийслэлийн хэмжээнд 888500 иргэдийг хамруулж хамрагдагчдын тоог 20219 оны суурь түвшинг 132049 хүнээр нэмэгдүүлсэн байна.<br>Хэрэгжилт 100% |
| 2. | | Арга хэмжээ 2. Өвлийн улиралд зохион байгуулах биеийн тамир, спортын үйл ажиллагааг өргөжүүлнэ. | Нийслэлийн төсвөөс 38,2 | Арга хэмжээнд оролцогчдын тоо (өссөн дүнгээр) | 410,000 | 2021 онд 411000<br>2022 онд 412000<br>2023 онд 413000<br>2024 онд 414000 | “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/06 дугаар захирамжаар биеийн тамир, спортын арга хэмжээ хязгаарлагдсан тул төлөвлөсөн ажлууд бүрэн хийгдээгүй. 2021 онд дүүргүүдийн орон сууц, гэр хорооллын 13 байршилд мөсөн гулгуурын талбай байгуулагдан 41600 иргэдэд, "Скай ресорт", “UB Resort”, “Хандгайт” “Пара тамирчдын бэлтгэлийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төв" цанын баазууд байгуулагдан 246,200 иргэдэд үйлчилгээ үзүүлж ажилласан байна.<br>2022 онд өвлийн улиралд зохион байгуулагдах арга хэмжээ, ажил үйлчилгээ, уралдаан тэмцээнд 424,972 иргэнийг хамруулсан.<br>2023 онд өвлийн улиралд зохион байгуулагдах арга хэмжээ, ажил үйлчилгээ, уралдаан тэмцээнд 425,100 иргэд, тамирчдыг хамруулсан.<br>2024 онд 414,200 иргэнд үйлчилгээ үзүүлж ажилласан байна. Үүнд: Нийслэлийн 9 дүүрэгт өвлийн спортын нийтийг хамарсан 10 арга хэмжээ зохион байгуулж 25.909 иргэнийг хамруулсан. Өвлийн спортын төрлөөр Улаанбаатар хотын аварга шалгаруулах уралдаан, тэмцээнийг 7 удаа зохион байгуулж 693 тамирчин оролцсон. Дүүргүүдийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багт өвлийн спортын 3 төрөл (хоккей, тэшүүр, шорт-трейк)-ийн төрлөөр 95 хүүхэд, багачууд секц, дугуйланд хамрагдсан. Монголын Тэшүүр, Хоккейн холбооны дэргэдэх бүртгэлтэй дугуйлан, секцэд 175 хүүхэд спортын 3 (тэшүүр, хоккей, уран гулгалт) төрөлд хамрагдсан. Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт байрлах битүү дээвэртэй мөсөн гулгуурын талбайд 2024 129.054 иргэн үйлчлүүлсэн. Сүхбаатар, Баянзүрх, Багануур дүүрэг дэх Хандгайт, Скай ресорт, Галуут тур, Улаанбаатар цанын баазуудад 153.000 иргэн үйлчлүүлсэн бол 22 байршилд мөсөн гулгуурын талбай байгуулагдаж 105.544 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна.<br><br>Үр дүн: Өвлийн улиралд биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлснээр 2019 онд 410,000 иргэдийг оролцуулж байсан бол 2024 онд 414200 хүн хамруулжээ.<br>Хэрэгжилт 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | | Арга хэмжээ 3. Иргэдэд үзүүлэх биеийн тамир, спортын үйлчилгээг чанаржуулах зорилгоор спортын клубуудыг магадлан итгэмжлэлд хамруулах ажлыг зохион байгуулах. | - | Магадлан итгэмжлэгд-сэн спорт клуб (өссөн дүнгээр) | 11 | 2021 онд 13<br>2022 онд 15<br>2023 онд 19<br>2024 онд 24 | Спорт клубүүдийг магадлан итгэмжлэлд хамрагдах зөвшөөрлийг Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооноос олгодог. Нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын хороод спорт клубүүдийг сайн дурын үндсэн дээр магадлан итгэмжлэлд хамрагдах чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгч магадлан итгэмжлэлд ороход бэлэн болсон материалуудыг Биеийн тамир, спортын улсын хороонд хүргүүлж ажилладаг. 2021 онд 2 спорт клуб магадлан итгэмжлэгдэж нийт 13 спорт клуб болсон.<br>2022 онд Налайх дүүргийн “Налайх спиннинг” клуб, Сонгинохайрхан дүүргийн “Бумба од” фитнес клубийн материалыг Биеийн тамир, спортын улсын хороонд хүргүүлсэн.<br>2023 онд 6 спорт клубт арга зүйн зөвлөгөө өгч магадлан итгэмжлэлд орох материалыг бэлтгэсэн боловч Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2019 оны А/178, А/144 дүгээр тушаалаар батлагдсан Спортын клубийн магадлан итгэмжлэх журмын холбогдох заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага тулгарсан тул түр хүлээгдсэн.<br>2024 онд Биеийн тамир, спортын тухай хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулан Биеийн тамир, спортын улсын хорооноос “Спорт клубийн магадлан итгэмжлэх журмыг шинэчилж байгаа тул магадлан итгэмжлэх спорт клубын материалыг хүлээн аваагүй бөгөөд энэ чиглэлээр зөвлөн туслах ажлыг хийж байна.<br>Үр дүн: Стандарт шаардлага хангасан орчинд магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрөөр мэргэжлийн багш дасгалжуулагч ажиллаж иргэдэд чанартай үйлчилгээ үзүүлэх чиглэлээр 2020 оноос хойш 2 спорт клуб магадлан итгэмжлэгдэж нийт 13 спорт клуб болоод байна. Энэ ажлыг үргэлжлүүлж 2022 онд 2 спорт клуб, 2023 онд 6 спорт клубийг |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | магадлан итгэмжлэлд оруулах материал бэлтгэгдсэн. 2024 онд магадлан итгэмжлэх чиглэлээр зөвлөн туслах ажлыг хийж байна. Хэрэгжилт 90% |
| Хэсгийн дундаж | | | | | | | 96,6% |
| 4. | Зорилт 2. Биеийн тамир, спортын байгууллагуудын чадамжийг дээшлүүлэх, хамтын ажиллагаанд тулгуурласан удирдлагын оновчтой тогтолцоог бий болгох. | Арга хэмжээ 1. Дүүргийн Биеийн тамир, спортын хороодын бүтцийг боловсронгүй болгож удирдлага зохион байгуулалтыг сайжруулна. | - | Нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын хороодын мэргэжилтний тоо (өссөн дүнгээр) | 63 | 2021 онд 63<br>2022 онд 77<br>2023 онд 83<br>2024 онд 84 | Биеийн тамир, спортын салбарын төв байгууллага Биеийн тамир, спортын улсын хороо нь 2021 онд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 47 дугаар тогтоолоор Засгийн газрын тохируулагч агентлаг болсонтой холбоотойгоор нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын хороод удирдлага, санхүүгийн босоо тогтолцоонд шилжиж салбарын жишиг бүтэц гарсан.<br>Биеийн тамир, спортын салбарын жишиг бүтцийн дагуу дүүргийн биеийн тамир, спортын хороод:<br>2021 онд 187 ажилтан, албан хаагч үүнээс биеийн тамирын асуудал хариуцсан 69 мэргэжилтэн ажилласан.<br>2022 онд 207 ажилтан, албан хаагч үүнээс биеийн тамирын асуудал хариуцсан 84 мэргэжилтэн ажилласан.<br>2023 онд 208 ажилтан, албан хаагч үүнээс биеийн тамирын асуудал хариуцсан 98 мэргэжилтэн ажилласан.<br>Биеийн тамир, спортын салбарын жишиг бүтцийн дагуу нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын газар, хороод 2024 оны жилийн эцсийн байдлаар 208 ажилтан, албан хаагч үүнээс биеийн тамирын асуудал хариуцсан 98 мэргэжилтэн ажиллаж байна. Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сул орон тоог төрийн албаны зөвлөлийн 2019 оны 25 дугаар тогтоолоор баталсан "Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам"-ын дагуу 2024 оны 05 дугаар сард зохион байгуулж 9 дүүргийн дарга нар жинхлэгдсэн. Тусгай шалгалт зохион байгуулах комиссын |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бүрэлдэхүүнд Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын дарга Ж.Ганболд орж ажилласан. Үр дүн: Нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын хороодод биеийн тамир, спортын асуудал хариуцсан мэргэжилтэн 2019 оны суурь түвшнээс 35 хүнээр нэмэгдэж 2021-2024 оны зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн. Салбарын жишиг бүтцийн дагуу хуульд заасан мэргэжил, мэргэшил, ур чадварыг хангасан албан хаагчдыг бүрдүүлэхээр нягтлан шалгах ажлыг зохион байгуулж, зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтийг хангран ажилласан. Хэрэгжилт 100% |
| 5. | | Арга хэмжээ 2. Дүүргийн хороодод орон тооны биеийн тамирын арга зүйчтэй болох асуудлыг шийдвэрлүүлэх. | - | Биеийн тамирын орон тооны арга зүйчдийн тоо (өссөн дүнгээр) | 0 | 2021 онд холбогдох байгууллагад санал хүргүүлэх 2022 онд 6 арга зүйч 2023 онд 9 арга зүйч 2024 онд 17 арга зүйч | Анхан шатны нэгжид биеийн тамир, спортын үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор дүүргийн хороодод орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллуулах саналыг Биеийн тамир, спортын улсын хороонд 2021 оны 2/73 албан тоотоор, 2022 онд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Хууль, эрх зүйн хэлтэст тус тус 3/235 албан тоотоор, 2023 онд Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хороонд 3/225 албан тоотоор, Биеийн тамир, спортын улсын хороонд 3/225 албан тоотоор тус тус хүргүүлсэн. Дээрх санал Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдан Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргэгдсэн. 2024 оны эхний хагас жилд “Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн Улсын Их хурлын хаврын чуулганаар “Сум, хороодод орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллаж биеийн тамир, спортын хуулийг хэрэгжүүлж орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлнэ” заалт батлагдсан. 2025 оноос эхлэн хэрэгжиж эхэлнэ. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Үр дүн: Хороодод орон тооны арга зүйч ажиллуулах заалт "Биеийн тамир, спортын тухай хууль"-д заалт болон тусгагдаж нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх боломж бүрдсэн. Хэрэгжилт 90% |
| 6. | | Арга хэмжээ 3 Аж ахуй нэгж байгууллага орон нутгийн нэгж хороодод биеийн тамирын хамтлаг байгуулах ажлыг эрчимжүүлж, мэргэжлийн удирдлагаар хангаж дэмжиж ажиллах. | - | Хамтлагийн тоо өссөн дүнгээр | 795 | 2021 онд 800<br>2022 онд 805<br>2023 онд 810<br>2024 онд 815 | Биеийн тамир, спортын үйлчилгээг байгууллагынхаа албан хаагчдад хүргэх, биеийн тамир, спортын үйл ажиллагаанд татан оролцуулах, хамт олны эерэг уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжид биеийн тамир, спортын хамтлагийг байгуулан ажиллаж зөвлөн туслах үйл ажиллагаа явуулж байна.<br>Тайлант хугацаанд 2021 онд 797 хамтлаг, 2022 онд 805 хамтлаг, 2023 онд 3 хамтлаг шинээр байгуулагдан нийт 808 хамтлаг үйл ажиллагаагаа явуулсан.<br>2024 онд нийслэлийн хэмжээнд 6 (БХД-ийн Ус суваг ашиглалтын товчоо, БХД-ийн тохижилт, БХД-ийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс, ХУД-ийн Мишээл, ХУД-ийн 326 дугаар цэцэрлэг, 322 дугаар цэцэрлэг) хамтлаг шинээр байгуулагдаж нийт 816 биеийн тамир, спортын хамтлаг үйл ажиллагаа явуулж байна. Биеийн тамир, спортын хамтлагийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, нийтэд таниулах, урамшуулах зорилгоор 6 хамтлагийг "Нийслэлийн шилдэг биеийн тамир, спортын хамтлаг"-аар шалгаруулан өргөмжлөл, цом, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан. Хамтлагийн үйл ажиллагаанд тулгуурлан Нийслэлийн иргэдийн спортын 12-р наадам, "Улаанбаатар марафонд нэгдэцгээе" цомын аяныг Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн хэмжээнд аялуулж, 145 удаагийн биеийн тамир, спортын уралдаан тэмцээн, өдөрлөг зохион байгуулж, 360 байгууллагын 68100 албан хаагчийг хамруулсан. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Үр дүн: Биеийн тамир, спортын хамтлагийн тоо 2019 онд 795 байсан бол 2021-2024 онд 21-ээр нэмэгдэж 816 болж хүрэх түвшинд бүрэн хүрсэн. Хэрэгжилт 100% |
| 7. | | Арга хэмжээ 4 Хүн амын бие бялдрын сорилын удирдлага зохион байгуулалтыг сайжруулан АВС үнэлгээтэй иргэдийн эзлэх хувийг нэмэгдүүлнэ. | - | АВС үнэлгээ-тэй иргэдийн эзлэх хувь өссөн дүнгээр | 53% | 2021 онд 54,5% 2022 онд 56% 2023 онд 57,5% 2024 онд 59% | 2021 онд Коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын тархалттай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийн дагуу хүн амын бие бялдрын хөгжилт, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах ажил зохион байгуулагдаагүй бол 2022 онд нийслэлийн хэмжээнд 87,356 иргэн хамрагдсан бөгөөд нийт хамрагдсан иргэдийн 60 хувь нь A, B, C үнэлгээ авсан байна.<br>2023 онд 175,500 иргэн хамрагдсанаас 82 хувь нь A, B, C үнэлгээ авсан байна.<br>Бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах ажлыг нийслэлийн хэмжээнд 2024 оны IV-VI, IX-XII саруудад зохион байгуулж 193,000 иргэн хамрагдсан бол сорилд хамрагдсан нийт иргэдийн 80 хувь нь A, B, C үнэлгээ авсан үзүүлэлттэй үнэлэгдсэн.<br>Үр дүн: Бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд 2019 онд нийт хамрагдсан иргэдээс 53 хувь нь A, B, C үнэлгээг авч байсан бол 2024 онд нийт хамрагдсан иргэдээс 80 хувь нь A, B, C үнэлгээ авсан. Хэрэгжилт 100% |
| Хэсгийн дундаж | | | | | | | 97,5% |
| Ерөнхий чиг үүргийн нэр: Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангуулах. | | | | | | | |
| Үндсэн чиг үүргийн нэр: Спортын сургалт дасгалжуулалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулж, өсвөрийн тамирчдын залгамж халааг бэлтгэн, тамирчдын спортын амжилтыг ахиулах. | | | | | | | |
| | Зорилт 3 Нийслэлд спортын төрлүүдийг хөгжүүлэх, | Арга хэмжээ 1 Багийн спортыг дэмжих замаар өсвөрийн хүүхэд, | Нийслэлийн төсвөөс 170.6 | Тэмцээн, уралдаанд оролцогчдын тоо (өссөн дүнгээр) | | 2021 онд 145100 2022 онд 145150 | Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын тархалттай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/06, Шадар сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8. | тамирчдын ур чадварыг дээшлүүлэх, гадаад харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэх. | багачуудыг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлнэ. | | | 145,000 | 2023 онд 145200<br>2024 онд 145250 | хамтарсан тушаалаар хичээл танхимын үйл ажиллагааг зайн сургалтад шилжүүлсэнтэй холбогдуулан "Улаанбаатар лиг" сагсан бөмбөг, волейбол, "Дуулиан" хөл бөмбөгийн тэмцээнүүдийг зохион байгуулах боломжгүй болсон ч сурагчдад зориулсан 51 удаагийн цахим дасгалыг "Нийслэлийн Спортын хороо" цахим хуудас болон Дүүргүүдийн биеийн тамир, спортын хороодын фейсбүүк групп, цахим хуудсанд байршуулан 20,333 хүүхэд, багачуудад хүргэсэн.<br>2022 онд нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд "Улаанбаатар лиг" сагсан бөмбөг, волейболын тэмцээн, иргэдийн дунд "UB CUP" "Нийтийн хөл бөмбөгийн фестиваль" зохион байгуулж 358 байгууллагын 125,214 хүүхэд, багачууд, тамирчин, иргэдийг хамруулсан.<br>2023 онд нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын "Улаанбаатар лиг" сагсан бөмбөгийн тэмцээн, "Улаанбаатар цом" хөл бөмбөгийн тэмцээн, "Улаанбаатар лиг" волейболын тэмцээн, Монголын хүүхдийн спортын VII наадмын нийслэлийн бүсийн тэмцээнийг багийн спортын 5 төрлөөр тус тус зохион байгуулж 298 байгууллагын 145,350 хүүхэд, багачууд, тамирчид хамрагдсан.<br>2024 онд "Улаанбаатар лиг" сагсан бөмбөг, волейбол, "Улаанбаатар цом", "Мөрөөдлийн гоол" хөл бөмбөгийн тэмцээнүүдийг зохион байгуулж 158,746 тамирчин, иргэд, хүүхэд, багачуудыг хамруулсан.<br>Үр дүн: Багийн спортын төрлөөр дамжуулан өсвөр үеийнхний бие бялдрыг хөгжүүлэх, хүмүүжил олгох, хамтач үзэл санааг төлөвшүүлэн 2019 оны суурь түвшин 145,000 хүн оролцуулж байсан бол 2024 онд 158,746 тамирчин, иргэд, хүүхэд, багачуудыг хамруулсан байна.<br>Хэрэгжилт 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9. | | Арга хэмжээ 2 Төрийн болон төрийн бус байгууллага, спортын холбоодын түншлэлд тулгуурлан уралдаан тэмцээний чанар зохион байгуулалтыг сайжруулна. | Улсын төсвөөс 51,4 Нийслэлийн төсвөөс 38,4 | Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнд оролцогч тамирчдын тоо (өссөн дүнгээр) | 7096 | 2021 онд 7134 2022 онд 7172 2023 онд 7210 2024 онд 7250 | Улсын онцгой комиссын даргын 2021 оны 41 дүгээр тушаал, 25 дугаар хуралдааны шийдвэрийн дагуу үзэгчгүйгээр тэмцээн, уралдаан зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлж спортын 21 холбоотой "Хариуцлагын гэрээ" байгуулан дүүргүүдийн Биеийн тамир, спортын хороодтой хамтран хяналт тавьж, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэн ажиллаж Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнийг спортын 15 төрлөөр зохион байгуулж 220 байгууллагын 2839 тамирчныг оролцуулсан.<br>2022 онд спортын 13 холбоотой хамтран ажиллах гэрээ байгуулан Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнийг 15 удаа зохион байгуулж 446 байгууллагын 7888 тамирчныг хамруулсан.<br>Үндэсний болон бусад спортын төрлүүдийг хөгжүүлэх, спортын холбоодыг дэмжих зорилгоор 2023 онд 24 спортын холбоодтой хамтран ажиллах, ажил гүйцэтгэх гэрээ байгуулж 30 тэмцээнийг зохион байгуулж 375 багийн 7967 тамирчин оролцсон бөгөөд шинэ тутам хөгжиж буй спортын төрлүүдийг нэмэгдүүлэх зорилгоор снөүбоард, виртуал дугуй, шорт трейк төрлийг зохион байгуулсан.<br>Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах, спортын холбоодын үйл ажиллагааг дэмжих зорилгоор 2024 оны жилийн эцсийн байдлаар 27 спортын холбоотой ажил гүйцэтгэх, хамтран ажиллах гэрээ байгуулж Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнийг спортын 23 төрлөөр, даншиг наадам 2 төрөл, нүүдэлчин дэлхийн соёлын фестивалийг зохион байгуулж 301 байгууллагын 7888 тамирчид оролцсон.<br>Үр дүн: 2019 онд Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнүүдэд нийт 7,096 тамирчин хамруулж байсан бол 2024 онд Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнийг спортын 23 төрлөөр зохион байгуулж 301 байгууллагын 7888 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тамирчид оролцсон. Мөн нийслэл, дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг 176 удаа зохион байгуулж 11422 байгууллагын 197275 тамирчид оролцсон<br>Хэрэгжилт 100% |
| 10 | | Арга хэмжээ 3 Зүүн азийн залуучуудын анхдугаар наадмыг зохион байгуулна. | - | Зүүн Азийн Залуучуудын анх-дугаар наадмын хэрэгжилтийн хувь | 0 | 2021 онд бэлтгэл ажил 30% 2022 онд бэлтгэл ажил 70% 2023 онд 100% | “Улаанбаатар -2023” Зүүн Азийн Залуучуудын наадмыг эх орондоо анх удаа 11 спортын 12 төрлөөр 2023 оны 08 дугаар сарын 16-аас 23-ны өдрүүдэд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод зохион байгууллаа.<br>Тус наадмын бэлтгэл ажлын 30%-ийг 2021 онд, 70 хувийг 2022 онд, 2023 онд 100% хангаж ажилласан.<br>Зүүн Азийн олимпын хороо нь есөн үндэсний олимпын хороог өөртөө нэгтгэдэг бөгөөд энэ удаагийн наадамд долоон үндэсний олимпын хорооны 880 тамирчин 8 өдрийн турш ур чадвар, авхаалж самбаа, хурд хүчээ сорин өрсөлдсөнөөс БНХАУ-ын баг, тамирчид 38 алт, 32 мөнгө, 19 хүрэл медаль авч багийн дүнгээр тэргүүлсэн бол Япон улс 22 алт, 7 мөнгө, 13 хүрэл, БНСУ 11 алт, 21 мөнгө, 24 хүрэл, Хятадын Тайвань 11 алт, 10 мөнгө, 21 хүрэл, Монгол улс 3 алт, 13 мөнгө, 28 хүрэл, Хятадын Хонконг 3 алт, 5 мөнгө, 12 хүрэл авсан амжилт үзүүлсэн байна.<br>“Улаанбаатар-2023” Зүүн Азийн Залуучуудын наадмын зохион байгуулалтын бэлтгэл ажлыг спорт, ёслолын ажиллагаа, наадмын байгууламжууд, байр, сууц, ажиллах хүч, хангамж, тээвэр, мэдээлэл технологи, хэвлэл мэдээлэл, олон улсын харилцаа, протокол, баталгаажилт, бүртгэл, аюулгүй байдал, олон нийттэй харилцах, маркетинг гэсэн 15 чиглэлд хуваан бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажиллаж амжилттай зохион байгууллаа. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Үр дүн: "Улаанбаатар -2023" Зүүн Азийн Залуучуудын наадмыг эх орондоо анх удаа зохион байгууллаа.<br>Хэрэгжилт 100% |
| 11 | | Арга хэмжээ 4 Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг удирдлагаар хангаж дэмжлэг үзүүлнэ. | Улсын төсвөөс 35,9 Орон нутгийн төсөв 206,5 Бусад 45,7 | Өсвөрийн шигшээ багуудын спортын төрлийг нэмэгдүүлнэ. | 22 | 2021 онд 22<br>2022 онд 23<br>2023 онд 24<br>2024 онд 25 | Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэхэд дэмжлэг үзүүлж ажилласны үр дүнд дүүргүүдийн Засаг дарга нарын дэргэдэх спортын шигшээ багийг 2021 онд спортын 24 төрлөөр 82 дасгалжуулагч, 1814 тамирчин хамрагдсан. 2022 онд спортын 3 төрөл (крикет, хоккей, усан спорт)-өөр нэмэгдүүлж 25 төрлөөр 65 багт 101 дасгалжуулагч, 2856 тамирчин хамрагдсан. 2023 онд 9 дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөр үеийн шигшээ багийг спортын 28 төрлөөр 105 дасгалжуулагч 2944 тамирчдын бүрэлдэхүүнтэйгээр бэлтгэл, сургуулилт, дасгалжуулалтад хамруулсан.<br>2024 онд дүүргүүдийн Засаг дарга нарын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж спортын 28 төрөлд 109 багт 109 дасгалжуулагчтай 3525 тамирчдыг бэлтгэл сургуулилтад хамруулж байна. Өсвөрийн шигшээ багийн тамирчид 2024 онд тив, дэлхий, олон улс, улс, нийслэл, нэрэмжит 521 удаагийн тэмцээнд оролцож 2707 медаль авсан амжилт үзүүлсэн бол Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй, Багануур, Налайх, Налайх дүүрэг өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг дэмжиж 288.2 сая төгрөгийг зарцуулсан байна.<br>Үр дүн: Тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэх зорилгоор өсвөрийн шигшээ багийг 2020 онд 22 спортын төрлөөр байгуулж сургалт дасгалжуулалт явуулж байсан бол 2024 онд спортын 28 төрөл болгон өргөжүүлж суурь түвшнээс 6 төрлөөр нэмэгдүүлж үйл ажиллагааг жигдрүүлж бэлтгэл сургуулилт, дасгалжуулалтад хамруулж байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хэрэгжилт 100% |
| Хэсгийн дундаж | | | | | | | 100% |
| 12. | Зорилт 4 Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандартын заал талбайн хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Арга хэмжээ 1 Олон улсын жишигт нийцсэн 30,000 – 40,000 хүний суудалтай шинэ цэнгэлдэх хүрээлэн шинээр барина. | - | Барилга угсралтын ажлын гүйцэт-гэлийн хувиар | ТЭЗҮ-г боловс-руулж байна. | 2021 онд ТЭЗҮ хийгдэх 2022 онд барилгыг эхлүүлэх 2023 онд гүйцэтгэл 70% 2024 онд гүйцэтгэл 100% | Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1046 дугаар “Газар эзэмших эрх олгох тухай” захирамжаар Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрших 30.0 га газарт “Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн” байгуулах зориулалтаар 15 жилийн хугацаатай газар эзэмших эрхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт олгосон.<br>Дээрх газар нь Байгаль орчны яаманд олгосон газруудтай давхцалтай байсан тул Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 07 тоот тушаал, Барилга хот байгуулалтын сайдын 2021 оны 02 дугаар сарын 10-ны 36 тоот тушаалаар дэд ажлын хэсгүүд байгуулагдан газрын маргаан, зөрчлийг шийдвэрлэхээр ажилласан боловч 2021-2023 онд газрын асуудал эцэслэн шийдэгдээгүйн улмаас зураг төсөв эцэслэн батлагдах, хөрөнгө шийдвэрлэх боломжгүй болсон.<br>Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн байгуулах талаар авах арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 315 дугаар тогтоол гарч хэрэгжиж байсан бөгөөд 2023 оны 162 дугаар тогтоолоор тус тогтоол хүчингүй болгосон байна. Олон Улсын жишигт нийцсэн 30.000-40.000 хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэн шинээр барих асуудал нь бодлогын баримт бичгүүдэд туссан 2020-2024 оны хүрэх түвшинд бүрэн хүрэх боломжгүй байгаа тул бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан заалтуудыг хасах санал гарган 2023 оны 3/222 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж ажилласан.<br>Үр дүн: Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн байгуулах талаар авах арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 315 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дугаар тогтоол гарч бэлтгэл ажил 30 хувьтай хэрэгжиж байсан бөгөөд 2023 оны 162 дугаар тогтоолоор тус тогтоол хүчингүй болгосон.<br>Хэрэгжилт 30% |
| 13. | | Арга хэмжээ 2 Нийслэл болон Сүхбаатар, Баянзүрх, Налайх, Баянгол, Багахангай дүүргийн спортын 6 цогцолборын барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | - | Нийслэл болон Сүхбаатар, Баянзүрх, Налайх, Баянгол дүүргийн спортын 5 цогцолборыг барьж ашиглалтад оруулсан байна. | 30-90% | 2021 онд 1<br>2022 онд 2<br>2023 онд 2<br>2024 онд 1 | Чингэлтэй дүүргийн спорт цогцолбор 2021 онд, 2022 онд Баянгол дүүргийн спорт цогцолбор ашиглалтад орсон.<br>2023 онд Нийслэл болон 6 дүүргийн спорт цогцолборын барилгын ажлыг үргэлжлүүлэхээр улсын төсөвт 5,043.6 төгрөг батлагдаж барилгын ажлын гүйцэтгэл 77 хувьд хүрсэн.<br>2024 онд: Налайх дүүргийн спорт цогцолборыг барих гүйцэтгэгчээр “Бүрд констракшн” ХХК шалгарч улсын төсвөөс 15.0 тэрбум төгрөгийн санхүүжилт авч 2012-2024 онд 100% гүйцэтгэн ашиглалтад оруулж Налайх дүүргийн Биеийн тамир, спортын хороо үйл ажиллагаагаа явуулж байна.<br>Багахангай дүүргийн спорт цогцолборын барилгын ажлын гүйцэтгэгчээр 2022 онд “Алтан шар говь” ХХК шалгарч улсын төсвөөс 2,415,6 сая төгрөгийн санхүүжилтээр барилгын ажлын 80 хувийг гүйцэтгэсэн. Баянзүрх дүүргийн спортын ордны бүтээн байгуулалтын ажил 85 хувьтай хэрэгжиж байгаа бөгөөд 2024 онд 2.58 тэрбум төгрөг батлагдаж далангийн ажил 80 хувьтай хийгдэж байна.<br>Сүхбаатар дүүргийн спорт цогцолборын барилгыг барих гүйцэтгэгчээр 2015 онд “Герийн ресурс” ХХК шалгарч улсын төсвөөс 5,200.0 сая төгрөгийн санхүүжилтийг авч тухайн спорт цогцолборын нийт ажлын 40 хувийг 2016-2020 онд хийж гүйцэтгэсэн боловч гэрээний хугацаа 2022 онд дуусгавар болсон тул Биеийн тамир, спортын улсын хороо Сангийн яаманд хүсэлт өгч гэрээ цуцалж спорт цогцолборын барилгыг Боловсрол, |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шинжлэх ухааны яаманд хариуцуулахаар 2024 оны 03-р сард хүсэлт өгсөн.<br>Нийслэлийн спорт цогцолборын гүйцэтгэгчээр 2010 онд "Үүрэг трейд" ХХК шалгарч барилгын ажлын 50 хувийг хийж гүйцэтгэсэн боловч газар нь Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 50 дугаар тогтоолын дагуу цэвэр усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсэд орсон тул барилгын ажил зогссон.<br>Үр дүн: Нийслэл болон төвийн 6 дүүрэгт баригдаж байгаа спорт цогцолборуудын барилгын ажлын явц 2020 онд 50 хувьтай хэрэгжиж байсныг үргэлжлүүлж 2021-2024 онд 80 хувьд хүргэсэн. Баянгол, Чингэлтэй, Налайх дүүргийн спорт цогцолборыг 2021-2023 онд тус бүр ашиглалтад оруулсан.<br>Хэрэгжилт 90% |
| 14. | | Арга хэмжээ 3 Нийслэлийн дэд төвүүдэд биеийн тамир, спортын барилга байгууламж, төрөлжсөн задгай талбайг төлөвлөх, барих асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана. | - | Дэд төвүүдэд ашиглалтад орсон спорт цогцолборуу-дын тоо | 0 | Баянхошуу дэд төвийн спорт цогцолбор 100% Дамбадар-жаа, Шархад дэд төвийн спортын цогцол-борын барилгын ажил 100 хэрэгжсэн байна. | Баянхошуу дэд төвийн спорт цогцолборыг барих худалдан авалтын үйл ажиллагааг 2021 онд "Улаанбаатар хотын Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр" төслийн нэгж зохион байгуулж "Стандарт холдинг" ХХК, "Химон констракшн" ХХК болон "Таны зам" ХХК-ны түншлэл гүйцэтгэгчээр шалгарч Нийслэлийн Засаг даргын тамгын газартай гурвалсан гэрээ байгуулсан. Спорт цогцолборын барилгыг 2022 онд нийт ажлыг 50 хувийг, 2023 онд нийт ажлын 65%-ийг 2024 онд 70 хувийг хийж гүйцэтгэсэн. Дамбадаржаа, Шархад дэд төвд баригдах спорт цогцолборын барилгыг хөрөнгө оруулалтын эх үүсвэр дутагдалтай байгаагаас шалтгаалан санхүүжүүлэгч байгууллага болох Азийн хөгжлийн банкны баталсан төлөвлөгөөнд тусгагдаагүй хасагдсан.<br>Спортын зориулалтын гадна талбай 2019 онд 101 байсан бол 2021 онд суурь судалгааг хийж Нийслэлийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хурлаар хэлэлцүүлж цаашид нэмэгдүүлэх чиглэл өгөгдсөний дагуу 2022 онд 4-өөр нэмэгдэж (Хан-уул дүүргийн 8 дугаар хороонд хөл бөмбөгийн талбай бүхий техникийн төв, 34, 52, 2-р сургуулиудын гадна талбайг хөл бөмбөгийн хиймэл зүлэг болон бусад тоноглолоор тохижуулсан) 105 болсон. 2023 онд 36 талбай (Нийслэлийн Хот тохижилтын газар хариуцан 3х3 сагсан бөмбөгийн 34 талбайг ашиглалтад оруулсан бол 57, 67-р сургуулийн спорт талбайг шинэчлэн тохижуулсан.)-аар нэмэгдэж 141 болсон. 2024 онд 62 (Нийслэлийн Хот тохижилтын газар хариуцан ажиллаж 3х3 сагсан бөмбөгийн 40 талбайг, Нийслэлийн Захирагчийн ажлын албанаас 20 байршилд байгуулсан. Мөн 22, 169-р сургуулийг биеийн тамирын гадна талбайг байгуулан ашиглалтад оруулсан)-аар 203 болсон.<br><br>Үр дүн: Шинэ дэд төвүүдэд баригдах спорт цогцолборын дахин давтагдах зураг төсөв хийгдэж Баянхошуу дэд төвийн спорт цогцолборын барилгын гүйцэтгэл 70 хувьд хүрсэн. Биеийн тамир, спортын зориулалтын талбай 2019 оны суурь үзүүлэлт 101 байсан бол 2022 онд 3, 2023 онд 36, 2024 онд 62-оор тус тус нэмэгдэж 203 болсон.<br><br>Хэрэгжилт 70% |
| Хэсгийн дундаж | | | | | | | 63.3% |
| Ерөнхий чиг үүргийн нэр: Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангах. | | | | | | | |
| Үндсэн чиг үүргийн нэр: Төрийн байгууллагын нийтлэг чиг үүрэг | | | | | | | |
| | Зорилт 5 | Арга хэмжээ 1 | | Тухайн жилийн | | | 2021 онд үндсэн үйл ажиллагааны чиглэлээр Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 15. | Төрөөс баримтлан бодлого болон биеийн тамир, спортын салбарын бодлого, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийг сайжруулахад хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж дүгнэлтээр хангах. | Биеийн тамир, спортын салбарын хүрээнд батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, тайлагнах | - | салбарын хууль, тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээ | - | - | хуулийн 7 заалт, Ерөнхийлөгчийн 3 зарлигийн 4 заалт, Ерөнхийлөгчийн 1 захирамжийн 1 заалт, Засгийн газрын 14 тогтоолын 27 заалт, Засгийн газрын 1 албан даалгаврын 1 заалт, Засгийн газрын 2 хуралдааны тэмдэглэлийн 3 заалт, Улсын Онцгой Комиссын 1 тогтоолын 2 заалт, Онцгой Комиссын 2 хурлын тэмдэглэлийн 2 заалтыг тус тус хяналтад авч 98 хувьтай буюу “бүрэн хэрэгжсэн” гэж үнэлэгдсэн.<br>2022 онд үндсэн үйл ажиллагааны чиглэлээр Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн 7 заалт, Ерөнхийлөгчийн 3 зарлигийн 3 заалт, Засгийн газрын 15 тогтоолын 29 заалт, Засгийн газрын 1 албан даалгаврын 1 заалтыг тус тус хяналтад авч 98 хувьтай хэрэгжүүлэн ажилласан буюу “бүрэн хэрэгжсэн” гэж үнэлэгдсэн.<br>2023 онд үндсэн үйл ажиллагааны чиглэлээр Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн 5 заалт, Ерөнхийлөгчийн 4 зарлигийн 4 заалт, Засгийн газрын 22 тогтоолын 34 заалт, Засгийн газрын хуралдааны 2 тэмдэглэлийн 4 заалт, Засгийн газрын 1 албан даалгаврын 1 заалтыг тус тус хяналтад авч 99 хувьтай буюу “бүрэн хэрэгжсэн” гэж үнэлэгдсэн.<br>2024 онд Биеийн тамир, спортын тухай хуулийн 12 заал, Ерөнхийлөгчийн 4 зарлигийн 4 заалт, Засгийн газрын 13 тогтоолын 24 заал, Засгийн газрын 04 хуралдааны тэмдэглэлийн 4 заалт, Засгийн газрын 01 дүгээр албан даалгаврын 5 заалт, Ерөнхий сайдын 01 дүгээр албан даалгаврын 2 заалтуудыг тус тус хяналтад авч 97 хувьтай буюу “бүрэн хэрэгжсэн” гэж үнэлэгдсэн.<br>Үр дүн: Хяналтад авагдсан хууль, тогтоомжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан.<br>Хэрэгжилт 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 16. | | Арга хэмжээ 2 Дүүргүүдийн Биеийн тамир, спортын хороодын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэргэжил арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх. | - | Хороодын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, мэргэжил арга зүйгээр хангасан байх. | 9 | 2021 онд 9<br>2022 онд 9<br>2023 онд 9<br>2024 онд 9 | Дүүргүүдийн биеийн тамир, спортын хороодын үйл ажиллагааны үр дүнг үнэлж, дүгнэх ажлыг 2021 онд Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас шалтгаалан зохион байгуулагдаагүй.<br>Дүүргүүдийн биеийн тамир, спортын хороодын үйл ажиллагааны үр дүнг үнэлж, дүгнэх ажлыг 2022-2024 онд зохион байгуулж эхний 4 байрыг шалгаруулсан бөгөөд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр зөвлөмж өгч ажиллаа.<br>Үр дүн: “Дүүргүүдийн биеийн тамир, спортын хороодын үйл ажиллагааны үр дүнг үнэлж, дүгнэн зөвлөмж өгч хэрэгжилтийн тайланг авч үнэлэлт, дүгнэлт өгдөг болсон.<br>Хэрэгжилт 100% |
| 17. | | Арга хэмжээ 3 Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх, албан хаагчдын ажиллах нөхцөл, ур чадварыг дээшлүүлэх мэргэшүүлэх сургалтад хамруулна. | - | Албан хаагчдын сургалтад хамрагдсан ажилтны тоо | - | - | Нийслэл дүүргийн Биеийн тамир, спортын ажилтан албан хаагчдын удирдлагын манлайллыг сайжруулах чиглэлээр 2021 онд 65 удаагийн сургалтад давхардсан тоогоор 1302 албан хаагч, 2022 онд 70 удаагийн сургалтад давхардсан тоогоор 1065 албан хаагч, 2023 онд 75 удаагийн сургалтад давхардсан тоогоор 1325 албан хаагч, 2024 онд 82 удаагийн сургалтад давхардсан тоогоор 1395 албан хаагчийг хамруулсан.<br>Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр гаргаж хэрэгжилтийг ханган ажиллаж Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын дагуу 7 үйл ажиллагаа 14 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хэрэгжилтийг тооцон хагас, бүтэн жилээр гарган Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн удирдлагын хэлтэст хүргүүлж ажилласан.<br>Үр дүн: Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр гаргаж хэрэгжилтийг хангаж ажилласан. Хэрэгжилт 100% |
| Хэсгийн дундаж | | | | | | | 100% |
| 18. | Зорилт 6 Гадаад харилцааг хөгжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх. | Арга хэмжээ 1 ОХУ, БНХАУ, БНСУ болон бусад улс орны биеийн тамир, спортын байгууллагууд-тай харилцан туршлага солилцон хамтран ажиллах. | Улсын төсвөөс 18,7 Нийслэлийн төсвөөс 161,7 | Хэрэгжил-тийн хувь | - | 2021 онд 100% 2022 онд 100% 2023 онд 100% 2024 онд 100% | Байгууллагын 2021 оны гадаад арга хэмжээний төлөвлөгөөнд 10 ажил гүйцэтгэхээр тусгаж 6 арга хэмжээг хэрэгжүүлж, 197 хүн оролцсон. Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлаас шалтгаалан төлөвлөсөн 4 арга хэмжээг зохион байгуулж чадаагүй. Дүүргүүдийн Засаг дарга нарын дэргэдэх өсвөр үеийн шигшээ багийн тамирчид олон улс, тив, дэлхийн чанартай тэмцээнүүдээс нийт 35 медаль хүртсэн.<br>Байгууллагын 2022 онд биеийн тамир, спортын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх төлөвлөгөөний дагуу 10-н ажил хэрэгжүүлж 788 хүн оролцсон. Дүүргүүдийн Засаг дарга нарын дэргэдэх өсвөр үеийн шигшээ багийн тамирчид олон улс, тив, дэлхийн чанартай 37 удаагийн тэмцээнд оролцож 176 медаль хүртсэн.<br>Байгууллагын 2023 оны гадаад арга хэмжээний төлөвлөгөөнд 6, нэмэлтээр 5 ажил тусган хэрэгжүүлж 1691 хүн оролцсон.<br>Дүүргүүдийн Засаг дарга нарын дэргэдэх өсвөр үеийн шигшээ багийн тамирчид олон улс, тив, дэлхийн чанартай 69 тэмцээнд оролцож 209 медаль хүртсэн амжилт гаргасан.<br>Байгууллагын 2024 оны гадаад арга хэмжээний төлөвлөгөөнд 9, нэмэлтээр 5 ажил хэрэгжүүлж 1691 хүн оролцсон. 2024 онд гадаад арга хэмжээнд улсын төсвөөс 18,729,000 төгрөг, нийслэлийн төсвөөс 161,711,000 төгрөг тус тус зарцуулсан.<br>Дүүргүүдийн Засаг дарга нарын дэргэдэх өсвөр үеийн шигшээ багийн тамирчид олон улс, тив, |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дэлхийн чанартай тэмцээнд 85 удаа оролцож нийт 395 медаль хүртсэн.<br>Үр дүн: Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж ажиллах тусгай төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг 100 хувь хангаж ажилласан. Мөн олимпын эрх олгох тэмцээн, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, “Улаанбаатар 2023” Зүүн Азийн залуучуудын наадмыг эх орондоо эрх авч зохион байгуулсан.<br>Хэрэгжилт:100 |
| Хэсгийн дундаж | | | | | | | 100% |
| Нийт хэсгийн дундаж | | | | | | | 93% |

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.САРАНЦЭЦЭГ

ТАЙЛАН ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА М.ЦОГЗОЛМАА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.БЯМБАСАЙХАН

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
2024 оны ..12.. дугаар сарын ..10..-ны өдрийн
..09/255.. дугаар албан бичгийн хоёрдугаар
хавсралт

9024010070 СТС4589 9077446

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

ИЛТГЭХ ХУУДАС

2024 оны 12 дугаар сарын 10 Улаанбаатар хот

# НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2021-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ–ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

## НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО:

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний 2024 оны биелэлтэд тухайн онд тавьсан зорилт, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлттэй харьцуулан тооцож, үр дүнг үнэлэн, дүгнэлт өгч, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

## ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ:

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний 2024 оны биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ийн 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу тооцож, арга хэмжээний дундаж үнэлгээгээр тус журмын 6.2.3 дахь заалтын дагуу шилжүүлэн тооцсон.

## ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН:

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний 2024 оны биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Үүнд:

(Хүснэгт)

| № | Бодлогын баримт бичигт тусгагдсан болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт | Стратеги арга зам | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2019 он) | Зорилтот түвшин (2024 он) | Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар) | ХШҮ-ний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Ерөнхий чиг үүргийн нэр:** Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангах. | | | | | | | |
| **Үндсэн чиг үүргийн нэр:** Иргэдийн идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлж, эрүүл мэндээ хамгаалах, хичээллэх орчин, нөхцөлийг бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй болгох. | | | | | | | |
| 1 | **Зорилт 1.** Иргэдэд хүргэх биеийн тамир, спортын арга хэмжээ, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. | **Арга хэмжээ 1.** Нийслэлийн иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн биеийн тамирын үйл ажиллагааг өргөжүүлж, нийтийг хамарсан арга хэмжээнүүдийг зохион байгуулна. | Биеийн тамирын үйл ажиллагаанд оролцогчдын тоо (өссөн дүнгээр) | 756,451 | 2021 онд 789451<br>2022 онд 822451<br>2023 онд 855451<br>2024 онд 888451 | Нийслэлийн иргэдийн бие бялдрыг чийрэгжүүлж, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, олон нийтийг хамарсан арга хэмжээнд өргөнөөр хамруулах зорилгоор:<br>2021 онд 635.486 иргэдийг хамруулсан.<br>2022 онд 1,170,073 иргэдийг хамруулсан.<br>2023 онд 873,313 иргэдийг хамруулсан.<br>2024 онд 888,500 иргэдийг хамруулсан. | 100 |
| 2 | | **Арга хэмжээ 2.** Өвлийн улиралд зохион байгуулах биеийн тамир, спортын үйл ажиллагааг өргөжүүлнэ. | Арга хэмжээнд оролцогчдын тоо (өссөн дүнгээр) | 410,000 | 2021 онд 411000<br>2022 онд 412000<br>2023 онд 413000<br>2024 онд 414000 | 2021 онд 416,000 иргэдийг хамруулсан.<br>2022 онд 424,972 иргэдийг хамруулсан.<br>2023 онд425,100 иргэдийг хамруулсан.<br>2024 онд 414,200 иргэдийг хамруулсан. | 100 |
| 3 | | **Арга хэмжээ 3.** Иргэдэд үзүүлэх биеийн тамир, спортын үйлчилгээг чанаржуулах зорилгоор спортын клубуудыг магадлан итгэмжлэлд хамруулах ажлыг зохион байгуулах. | Магадлан итгэмжлэгдсэн спорт клуб (өссөн дүнгээр) | 13 | 19 | 2021 онд 13<br>2022 онд 13<br>2023 онд 6 спорт клубийг магадлан итгэмжлэлд оруулах материал бэлтгэгдсэн.<br>2024 онд магадлан итгэмжлэх чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. | 90 |
| **Зорилтын дундаж 96.6%** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | **Зорилт 2.** Биеийн тамир, спортын байгууллагуудын чадамжийг дээшлүүлэх, хамтын ажиллагаанд тулгуурласан удирдлагын оновчтой тогтолцоог бий болгох. | **Арга хэмжээ 1.** Дүүргийн Биеийн тамир, спортын хороодын бүтцийг боловсронгуй болгож удирдлага зохион байгуулалтыг сайжруулна. | Нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын хороодын мэргэжилтний тоо (өссөн дүнгээр) | 63 | 2021 онд 63<br>2022 онд 77<br>2023 онд 83<br>2024 онд 84 | Биеийн тамир, спортын салбарын жишиг бүтцийн дагуу дүүргийн биеийн тамир, спортын хороод:<br>2021 онд 69 мэргэжилтэн<br>2022 онд 84 мэргэжилтэн<br>2023 онд 98 мэргэжилтэн<br>2024 он 110 мэргэжилтэн | 100 |
| 5 | | **Арга хэмжээ 2.** Дүүргийн хороодод орон тооны биеийн тамирын арга зүйчтэй болох асуудлыг шийдвэрлүүлэх. | Биеийн тамирын орон тооны арга зүйчдийн тоо (өссөн дүнгээр) | 0 | 2021 онд холбогдох байгууллагад санал хүргүүлэх<br>2022 онд 6 арга зүйч<br>2023 онд 9 арга зүйч<br>2024 онд 17 арга зүйч | Аанхан шатны нэгжид биеийн тамир, спортын үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор дүүргийн хороодод орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллуулах саналыг 2021-2023 оны хооронд 6 удаагийн албан бичгээр хүргүүлсэн.<br>2024 онд “Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн Улсын Их хурлын хаврын чуулганаар “Сум, хороодод орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллаж биеийн тамир, спортын хуулийг хэрэгжүүлж орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлнэ” заалт батлагдсан. 2025 оноос эхлэн хэрэгжиж эхэлнэ. | 90 |
| 6 | | **Арга хэмжээ 3** Аж ахуй нэгж байгууллага орон нутгийн нэгж хороодод биеийн тамирын хамтлаг байгуулах ажлыг эрчимжүүлж, мэргэжлийн удирдлагаар хангаж дэмжиж ажиллах. | Хамтлагийн тоо өссөн дүнгээр | 795 | 2021 онд 800<br>2022 онд 805<br>2023 онд 810<br>2024 онд 815 | 2021 онд 797 хамтлаг<br>2022 онд 805 хамтлаг<br>2023 онд 808 хамтлаг<br>2024 онд 816 хамтлаг | 100 |
| 7 | | **Арга хэмжээ 4** Хүн амын бие бялдрын сорилын удирдлага зохион байгуулалтыг сайжруулан АВС үнэлгээтэй иргэдийн эзлэх хувийг нэмэгдүүлнэ. | АВС үнэлгээтэй иргэдийн эзлэх хувь өссөн дүнгээр | 53% | 2021 онд 54,5%<br>2022 онд 56%<br>2023 онд 57,5%<br>2024 онд 59% | 2021 онд /Ковид-19/-ын тархалттай холбогдуулан сорил авах ажил хийгдээгүй.<br>2022 онд 60 хувь<br>2023 онд 82 хувь<br>2024 онд 80 хувь | 100 |
| **Зорилтын дундаж** | | | | | | | 97.5% |
| **Ерөнхий чиг үүргийн нэр:** Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангуулах. | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Үндсэн чиг үүргийн нэр:** Спортын сургалт дасгалжуулалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулж, өсвөрийн тамирчдын залгамж халааг бэлтгэн, тамирчдын спортын амжилтыг ахиулах. | | | | | | | |
| 8 | **Зорилт 3**<br>Нийслэлд спортын төрлүүдийг хөгжүүлэх, тамирчдын ур чадварыг дээшлүүлэх, гадаад харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэх. | **Арга хэмжээ 1**<br>Багийн спортыг дэмжих замаар өсвөрийн хүүхэд, багачуудыг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлнэ. | Тэмцээн, уралдаанд оролцогчдын тоо (өссөн дүнгээр) | 145,000 | 2021 онд 145100<br>2022 онд 145150<br>2023 онд 145200<br>2024 онд 145250 | 2021 онд 20,333<br>2022 онд 125,214<br>2023 онд 145,350<br>2024 онд 158,746 | 100 |
| 9 | | **Арга хэмжээ 2**<br>Төрийн болон төрийн бус байгууллага, спортын холбоодын түншлэлд тулгуурлан уралдаан тэмцээний чанар зохион байгуулалтыг сайжруулна. | Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнд оролцогч тамирчдын тоо (өссөн дүнгээр) | 7096 | 2021 онд 7134<br>2022 онд 7172<br>2023 онд 7210<br>2024 онд 7250 | 2021 онд 2839 тамирчин<br>2022 онд 7888 тамирчин<br>2023 онд 7967 тамирчин<br>2024 онд 7888 тамирчин | 100 |
| 10 | | **Арга хэмжээ 3**<br>Зүүн азийн залуучуудын анхдугаар наадмыг зохион байгуулна. | Зүүн Азийн Залуучуудын анхдугаар наадмын хэрэгжилтийн хувь | 0% | 2021 онд бэлтгэл ажил 30%<br>2022 онд бэлтгэл ажил 70%<br>2023 онд 100% | 2021 онд наадмын бэлтгэл ажлын 30%<br>2022 онд наадмын бэлтгэл ажлын 70%<br>2023 онд "Улаанбаатар-2023" Зүүн Азийн Залуучуудын наадмыг эх орондоо анх удаа 11 спортын 12 төрлөөр 2023 оны 08 дугаар сарын 16-наас 23-ны өдрүүдэд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод зохион байгуулсан. | 100 |
| 11 | | **Арга хэмжээ 4**<br>Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг удирдлагаар хангаж дэмжлэг үзүүлнэ. | Өсвөрийн шигшээ багуудын спортын төрлийг нэмэгдүүлнэ. | 22 | 2021 онд 22<br>2022 онд 23<br>2023 онд 24<br>2024 онд 25 | 2021 онд 24 төрөл<br>2022 онд 25 төрөл<br>2023 онд 28 төрөл<br>2024 онд 28 төрөл | 100 |
| **Зорилтын дундаж** | | | | | | | **100%** |
| 12 | **Зорилт 4**<br>Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандартын заал талбайн хүртээмжийг нэмэгдүүлнэ. | **Арга хэмжээ 1**<br>Олон улсын жишигт нийцсэн 30,000 – 40,000 хүний суудалтай шинэ цэнгэлдэх хүрээлэн шинээр барина. | Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн хувиар | ТЭЗҮ-г боловсруулж байна. | Барилга угсралтын ажлыг 70% хүргэнэ. | 2021 он, 2022 онд газрын асуудал, хөрөнгө шийдвэрлэгдээгүй.<br>2023 онд 162 дугаар тогтоолоор тус тогтоол хүчингүй болгосон.<br>2020-2024 оны хүрэх түвшинд бүрэн хүрэх боломжгүй байгаа тул бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан заалтуудыг хасах санал гарган 2023, 2024 онд албан бичгээр | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж ажилласан. | |
